

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн  
дэд даргын 2021 оны 21 дугаар тушаалын  
21 дүгээр хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### ИЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Албан тушаалын нэр:

Хууль, шүүхийн байгууллагад Засгийн газар, Ерөнхий сайдыг төлөөлөх асуудал, УИХ-ын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газарт тавьсан асуулга, асуулт хариуцсан Засгийн газрын референт

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Хууль, эрх зүйн газар

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эрхэлсэн түшмэл, АА-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар -12, Төрийн ордон

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II: АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль, шүүхийн байгууллагад Засгийн газар, Ерөнхий сайдыг төлөөлөх, удирдлагын шийдвэрээр тодорхой салбарт хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, хариуцсан салбараас боловсруулсан хууль тогтоомжийн төслийг хянах, дун шинжилгээ хийх, удирдлагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл,

Албан тушаалын зорилт:

- 1.Хариуцсан салбарын болон удирдлагын шийдвэрээр холбогдох бусад салбар /цаашид "хариуцсан салбар" гэх/-т хамаарах хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, хариуцсан салбараас боловсруулсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслийг хянаж, энэ талаар холбогдох шийдвэр гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зохицуулалтаар хангах;
- 2.Хууль, шүүхийн байгууллагаад Засгийн газар, Ерөнхий сайдыг төлөөлөх, хариуцсан салбар, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу төрийн бусад байгууллагаас ирүүлсэн асуудлаар санал дүгнэлт, шаардлагатай мэдээлэл, лавлагаа, танилцуулга бэлтгэх, зохих шийдвэрийн төсөл боловсруулах;
- 3.Хариуцсан салбарт хамаарах асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төсөлд санал бэлтгэх;
- 4.Хариуцсан салбарт хамаарах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулга, асуултын хариуг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах, байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;
5. Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
	1.Хариуцсан салбар болон холбогдох бусад салбарт хамаарах хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судалж, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах, батлуулах;	Төсөл нь хуульд заасан шаардлага хангасан, найруулга зүйн алдаагүй байна.	X, Г
1 дүгээр зорилтын хүрээнд	2.Хариуцсан салбарт хамаарах хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага, үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах;	Төсөл нь хуульд заасан шаардлага хангасан, найруулга зүйн алдаагүй байна.	X, Г
	3.Засгийн газрын шийдвэрийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлага, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын бодлого, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулах;	Төсөл нь хууль тогтоомжид нийцэнхэд судалгаа, нотолгоонд үндэслэсэн байна.	


	<p>4.Хариуцсан салбараас боловсруулсан хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээр, Засгийн газрын шийдвэрийн төслийг хянаж, санал бэлтгэх, энэ талаар холбогдох шийдвэр гаргахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зохицуулалтаар хангах;</p>	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
	<p>5.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслийн талаар яам, холбогдох байгууллагын саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Засгийн газрын гишүүдийн саналыг төсөлд тусгаж, албажуулах;</p>	Төсөл нь хуульд заасан шаардлага хангасан, найруулга зүйн алдаагүй байна.	X, Г
	<p>6.Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангах, Улсын Их Хурлын Байнгын хороодын хуралдаан, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд оролцох.</p>	Хууль тогтоомжийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан байна.	X, Г
2 дугаар зорилтын хрээнд	<p>1.Хууль, шүүхийн байгууллагаас эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-ыг төлөөлж оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж ирүүлэх тухай албан бичгийг судлах, хэрэг маргааны төрөл, нэхэмжлэлийн шаардлагын агуулгаас хамааран холбогдох яам, Засгийн газрын агентлагийн албан тушаалтныг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилох Ерөнхий сайдын захирамжийн төсөл, сайдын тушаалын төслийг боловсруулж, албажуулах, тэдгээрийн хувийг хууль, шүүхийн байгууллагад хүргүүлэх, итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт мэдэгдэх, хэргийн явц байдалд хяналт тавих, бүртгэл хөтлөх, удирдлагыг холбогдох мэдээллээр хангах;</p>	Хууль, шүүхийн байгууллагатай харилцах асуудлыг хуулийн дагуу хугацаанд нь шуурхай зохион байгуулсан байх, бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлсөн байна.	X, Г
	<p>2.Хууль, шүүхийн байгууллагаас эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Засгийн газар, Ерөнхий сайд,</p>	Төлөөллийг хуульд заасны дагуу хэрэгжүүлж, хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г



	ЗГХЭГ-ыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох;		
	3.Хууль, шүүхийн байгууллага болон удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу бусад байгууллагаас ирүүлсэн асуудлаар санал дүгнэлт, шаардлагатай мэдээлэл, лавлагаа, танилцуулга бэлтгэх, зохих шийдвэрийн төсөл боловсруулах;	Санал, дүгнэлт, мэдээлэл, лавлагаа, танилцуулга болон зохих шийдвэрийн төсөл нь боловсруулалтын шаардлага хангасан, холбогдох хуульд нийцсэн байна.	X, Г
	4.Хууль, шүүхийн байгууллагаас шаардсан нотлох баримтыг удирдлагаас өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хүргүүлэх;	Нотлох баримтыг зохих журмын дагуу хугацаанд нь хүргүүлсэн байна.	X, Г
	5.Хууль, шүүхийн байгууллагаас нэхэмжлэлийн хувийг гардаж авах, нэхэмжлэлийн шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, хариу тайлбарын төсөл боловсруулах, нотлох баримт цуглуулах, тайлбар, нэхэмжлэлийг нотлох баримтын хамт хууль, шүүхийн байгууллагад хүргүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тайлбар, мэдүүлэг өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, туршилт, үзлэг хийлгэх хүсэлт гаргах, шүүх хуралдаанаас өмнө хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой аливаа ажиллагаанд төлөөлүүлэгчийг төлөөлэн оролцох;	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөллийг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна.	X, Г
	6.Анхан шатны шүүх хуралдаанд бэлтгэх, оролцох, шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдолд хариу тайлбар гаргах, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох, хэрэг маргааныг шүүхийн бүх шатанд эцэслэн хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад ажиллагаанд оролцон төлөөлүүлэгчийн эрх, ашиг	Төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасны дагуу бүрэн хамгаалах, хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, тухайн жилийн хэрэг маргааны талаар тайлгагнасан байна.	X, Г



	сонирхлыг хамгаалах, шаардлагатай хууль зүйн туслалцааг үзүүлэх, шүүхээр эцэслэн хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргааны талаар удирдлагад танилцуулах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой холбогдох арга хэмжээг зохион байгуулах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шаардлагатай бол оролцох, тухайн жилийн хэрэг маргааны талаар тайлагнах;		
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хариуцсан салбарт хамаарах асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн төслийн бурдлийг хянаж, Засгийн газраас өгөх санал, дүгнэлт бэлтгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
	2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг хянаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган тэмдэглэлийн төслийг албажуулах ажлыг зохион байгуулах;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
	3.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийг төсөл санаачлагчид хүргүүлэх.	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Хариуцсан салбарт хамаарах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулга, асуултын хариуг холбогдох яам, агентлагаар бэлтгүүлэн хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, хүргүүлэхэд бэлтгэх;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
	2.Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулга, асуултын	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г



	хариуг хариуцсан референт холбогдох яам, агентлагаар бэлтгүүлэн боловсруулсан хувилбарыг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;		
	3.Байгууллага, аж ахуйн нэгжээс хандаж тавьсан санал, хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах;	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
	4.Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хариу бэлтгэн хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;	Хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	X, Г
	5.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хариу бэлтгэж, хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	X, Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.ЗГХЭГ-ын удирдлага, нэгжийн даргаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврыг биелүүлэх, Ерөнхий сайдын захирамж, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулсан холбогдох Ажлын хэсэгт орж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	2.Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн санал хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах, асуудлыг судалж хариу төлөвлөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг судалж удирдлагад танилцуулж зохих журмын дагуу шийдвэрлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г
	3.Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлын хяналтын картыг тухай бүрт нь хаах, үйл ажиллагааны явцад гарсан баримт бичгийг ангилан хэрэг бүрдүүлж, Засгийн газрын архивт зохих журмын дагуу шилжүүлсэн байх;	Холбогдох тогтоомжид байна.	



	4. Тухайн албан тушаалын чигүүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох нууцын баталгааг авахад шаардагдах материалыг гаргаж өгөх.	Холбогдох тогтоомжид байна.	хууль нийцсэн	Г
--	--	-----------------------------	---------------	---

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.			
Мэргэжил	-эрх зүй /0421/.			
Мэргэшил	-Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.			
Туршлага	Төрийн албананд 12-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.			
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- төр засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх, үр дүнг тайлагнах;</li> <li>- байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийг ойлгож хэрэгжүүлэх;</li> <li>- албан үүргээ гүйцэтгэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлох, бууруулах арга хэмжээ авах;</li> <li>- санаалын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- бусад.</li> </ul>		
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- хариуцсан салбараас боловсруулсан хууль тогтоомжийн төслийг холбогдох хууль тогтоомжтой харьцуулан судалж, бодлогын үндэслэлтэй санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;</li> <li>- хариуцсан асуудлаар бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;</li> <li>- бусад.</li> </ul>		
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;</li> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- аливаа харилцааг зохицуулах арга замыг тогтоол, шийдвэрийн төсөлд тусгах санал боловсруулах;</li> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> <li>- хууль тогтоомжийн төслийн заалтын давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог хангах саналыг хууль тогтоомжийн төсөлд тусгах;</li> </ul>		



		<ul style="list-style-type: none"> <li>- бусад.</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- байгууллагын үйл ажиллагааны шинэ тээлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</li> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байж, бусдыг дэмжих, чиглүүлэх зэрээр үргэрлэх;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- хууль зүйн техникийн болон практик ур чадвар эзэмшсэн байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалтын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвартай байх;</li> <li>- иргэн, албан тушаалтан, гишүүдтэй зелдэг, соёлтой, хүндэтгэлтэй харилцах;</li> <li>- худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээ авсан байх;</li> <li>- төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг бичгээр зөвшөөрч, эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн байх;</li> <li>- кирил болон үндэсний бичгээр боловсруулах чадвартай байх.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шүүд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Хууль, эрх зүйн газрын дарга

Албан тушаалд шүүд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:   
 1.УИХ-ын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Төрийн албаны зөвлөл, яам, агентлаг, нутгийн захиргааны болон бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан.  
 2.Иргэн, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: ДЭД ДАРГА

У.БЯМБАСҮРЭН

(Гарын үсэг)

(Эцэг/эх-/ийн нэр,  
өөрийн нэр)

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,  
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын  
шийдвэр:

Байгууллагын нэр:  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

21 09 14

Дугаар:

219

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:


ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо: Тэргүүн дэд даргын 2021 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн тушаал

Дугаар: 211

(тамга/тэмдэг)

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



Б.ГАНБАТ

(Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)